**МОНГОЛ УЛСЫН ИХ ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД СУРАЛЦАГЧДАД СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ХӨНГӨЛӨЛТ ЧӨЛӨӨЛӨЛТ ХАМРАГДАХ ОЮУТНЫ ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ**

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1 Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 46 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Монгол улсын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад төрийн буцалтгүй тусламж олгох журам" /цаашид "журам" гэнэ/-ын дагуу өмчийн хэлбэр харгалзахгүй Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллеж /цаашид "сургууль" гэнэ/-д боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтарсан шийдвэрээр олгосон хяналтын тоонд багтаж, өдрийн ангид бакалавр, магистр, докторын боловсрол эзэмшихээр томилолт авсан суралцагчид сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж /цаашид "буцалтгүй тусламж" гэнэ/ олгох харилцааг зохицуулж, оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлоход энэхүү гэрээний зорилго оршино.

**Хоёр. Гэрээнд оролцогч талууд**

2.1. Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежид суралцагчдад буцалтгүй тусламж олгох тухай гэрээ /цаашид "гэрээ" гэнэ/-г хянан баталгаажуулж, санхүүжилт хийх үүрэг бүхий сумын Засаг даргын тамгын газрыг төлөөлж ...Засаг дарга... –ын албан тушаалтай ...Жамъяртогоо... овогтой ...Цэвгээнаа... ; суралцагч ..."Их засаг" ИС... сургуульд...Нягтлан бодогч...мэргэжлээр бакалавр / магистр / докторын зэргийн боловсрол эзэмшихээр суралцаж буй Дундговь...аймаг/хотын Баянжаргалан сум / дүүргийн 3 -р баг / хорооны ...Доно 5-5... гудамж / байрны ...5-5... тоотод оршин суугч 3Б01312319... регистрийн дугаартай Батсайхан... овогтой Отгонбат... нар дараах нөхцөлийг харилцан хүлээн зөвшөөрч, энэхүү гэрээг байгуулав.

**Гурав. Сургалтын төлбөрийн эрх, үүрэг**

3.1. Энэхүү гэрээний 1.1-д заасан сургуульд суралцаж байгаа суралцагчид буцалтгүй тусламж олгохдоо боловсролын болон санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас хамтран баталсан төрөөс хариуцах санхүүжилтийн хэмжээг баримтална.

3.2. Санхүүжилтийн тооцоог тухайн сургуулийн нэхэмжлэлийн дагуу сургуулийн дансанд шилжүүлнэ. Сургалтын төлбөрийг хичээлийн улирлаар тооцон санхүүжүүлэх зарчим баримтлана.

3.3. Суралцагчийн сурлага, шилжилт хөдөлгөөн, дүнгийн байдлын талаар сургуулиас ирүүлсэн мэдээлэл, тодорхойлолтыг үндэслэн гэрээг сунгах, түдгэлзүүлэх, цуцлах, дуусгавар болгох арга хэмжээг авна.

**Дөрөв. Суралцагчийн эрх, үүрэг**

4.1.Суралцагч........Их засаг........ сургуульд, II курст,.......Нягтлан бодогч....... мэргэжлээр, 3.0 голч дүнтэй, ............ жилийн хугацаатайгаар суралцах нөхцөлийг тохирч, энэхүү гэрээг байгуулав.

4.2. Журамд заасан нөхцөлүүдийн аль нэг заалтаар буцалтгүй тусламж авахаа тодорхойлж, шаардагдах бичиг баримтыг үнэн зөвөөр жил бүрийн 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор бүрэн бүрдүүлж сургуульдаа өгнө.

4.3. Суралцагч нь хувийн мэдээлэл, сурлага, шилжилт хөдөлгөөн, дүнгийн байдлын тухай сургуулийнхаа сургалтын албанд цаг тухайд нь мэдээлж байна.

4.4. Суралцагч суралцах хугацаандаа хичээлийн жилийн улирал бүрийн эхэнд энэхүү гэрээтэй танилцан гэрээг сунгах, түдгэлзүүлэх, цуцлах, дуусгавар болгох тухай бичилт хийсэн эсэхэд хяналт тавина.

4.5. Суралцагч энэхүү гэрээний 4.1 дэх хэсэгт заасан голч дүнгийн босгын шаардлага хангахгүй суралцсан эсхүл хугацааны нөхцөл болон журамд заасан бусад нөхцөлийг зөрчсөн тохиолдолд авсан сургалтын төлбөр, тэтгэлэггүй дүйцэх хэмжээний мөнгийг буцаан төлнө.

4.6. Суралцагч энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ өөрийн биеэр биелүүлэх боломжгүй тохиолдолд түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч болох 3Ю64063000 регистрийн дугаартай Иргэндэмид... овогтой ...Цэвэлмаа... биелүүлнэ.

4.7. Сумын ЗДТГ-аас Их дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад сургалтын төлбөрийн хөнгөлөлт чөлөөлөлтөд хамрагдаж буй оюутан, залуус сумандаа 5 жилийн хугацаатай гэрээ байгуулан ажиллана.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГА:

.................................................. Т.ЦЭВЭЛМАА

Гарын үсэг

ИХ, ДЭЭД СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧ:

Батсайхан овогтой ...Отгонбат...

...У. Цэвэлмаа...

гарын үсэг

2022 он ...03... сар ...10... өдөр